

Цаашдын чиглэл

○ Японоос гарах гадаад иргэд нэмэгдэж байгаа тул, онцгой журмаар оршин суух зөвшөөрөлтэй байсан гадаад иргэдийг зөвшөөрлийн үлдэгдэл хугацаанд нь нийцүүлэн доорох мэт **эх орон руу буцах** арга хэмжээг авна.

I. Зөвшөөрөл дуусах хугацаа 6 сарын 29-нөөс өмнө бол

Дараах зарчмаар оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгагдана.

а. “Тусгай үйл ажиллагаа” (6 сар) зэрэг зөвшөөрөлтэй бол: **“Тусгай үйл ажиллагаа” (4 сар)**

б. “Богино хугацааны оршин суух” (90 хоног) зөвшөөрөлтэй бол: **“Богино хугацааны оршин суух (90 хоног)”**

Жич 1: Одоо зөвшөөрөгдөж буй нөхцөлийн хүрээнд хөдөлмөр эрхлэх эрхтэй.

Жич 2: Дараа удаагийн хугацаа сунгалтаар “тусгай үйл ажиллагаа (4 сар)” эсвэл “богино хугацааны оршин суух (90 хоног)”-ийг **“нэг л удаа”** олгоно.

II. Зөвшөөрөл дуусах хугацаа 6 сарын 30-наас хойш бол

Дараах зарчмаар оршин суух тусгай зөвшөөрлийн хугацаа **“нэг л удаа”** сунгагдана.

а. “Тусгай үйл ажиллагаа” (6 сар) зэрэг зөвшөөрөлтэй бол: **“Тусгай үйл ажиллагаа” (4 сар)**

б. “Богино хугацааны оршин суух” (90 хоног) зөвшөөрөлтэй бол: **“Богино хугацааны оршин суух” (90 хоног)**

Жич 1: Одоо зөвшөөрөгдөж буй нөхцөлийн хүрээнд хөдөлмөр эрхлэх эрхтэй.

Жич 2: Эх орон руу буцахад хүндрэлтэй гэх шалтгаантай хугацаа сунгалт нэг л удаа учраас зөвшөөрөгдсөн хугацаанд багтааж нутаг руу буцах бэлтгэлээ хангаарай.

Жич 3: Дээрх сунгалтаар олгосон хугацаа дууссан бол **зөвшөөрөл дахин сунгагдахгүй**.

III. Эх орон руу буцахад хүндрэлтэй байдал хэвээр тул тусгай зөвшөөрлийг шинэчлэн хүсэхээр бол

Одоо байгаа оршин суух зөвшөөрөл хэрэв **2022 оын 11 сарын 1-нээс өмнө** дуусах тохиолдолд, дээрх II-д заасан **“нэг л удаа”**-гийн арга хэмжээнд хамрагдана.

Жич: “Тусгай үйл ажиллагаа” (ажлын байр хадгалах) зөвшөөрөлтэй бол дээддээ нэг жилээр (* **“нэг л удаа”**) сунгагдана.

* **Тус “нэг л удаа”-гийн зөвшөөрөл авах хүсэлттэй бол “Тодорхойлолт” гаргах хэрэгтэй.**

Онцгой арга хэмжээ цуцлах болсонтой холбогдуулан түүнд хамрагдах хүмүүс



2022 оны 5 сарын 31
Японы Гадаад иргэн
харьяатын газар
Immigration Services Agency of Japan

	Ангилал	Өмнөх нөхцөл	Шинээр үүсэх нөхцөл
1	Ур чадварын дадлагажигч байсан	Тусгай үйл ажиллагаа (6 сар / Эх орон руу буцахад хүндрэлтэй / Хөдөлмөрлөх эрхтэй)	Тусгай үйл ажиллагаа (4 сар / Эх орон руу буцахад хүндрэлтэй / Хөдөлмөрлөх эрхтэй)
2	Гадаад оюутан байсан	Тусгай үйл ажиллагаа (6 сар / Эх орон руу буцахад хүндрэлтэй / Долоо хоногт 28 цаг хүртэл хөдөлмөрлөх эрхтэй)	Тусгай үйл ажиллагаа (4 сар / Эх орон руу буцахад хүндрэлтэй / Долоо хоногт 28 цаг хүртэл хөдөлмөрлөх эрхтэй)
3	Дунд, урт хугацааны оршин суугч байсан	Тусгай үйл ажиллагаа (6 сар / Эх орон руу буцахад хүндрэлтэй / Хөдөлмөрлөх эрхгүй) (*)	Тусгай үйл ажиллагаа (4 сар / Эх орон руу буцахад хүндрэлтэй / Хөдөлмөрлөх эрхгүй) (*)
4	Богино хугацааны оршин суух зөвшөөрөлтэй	Богино хугацааны оршин суух (90 хоног / Эх орон руу буцахад хүндрэлтэй / Хөдөлмөрлөх эрхгүй) (*)	Богино хугацааны оршин суух (90 хоног / Эх орон руу буцахад хүндрэлтэй / Хөдөлмөрлөх эрхгүй) (*)
5	Ажлын байр хандгалах арга хэмжээнд хамрагсад	Тусгай үйл ажиллагаа (Дээддээ нэг жил / Ажлын байр хадгалах / Хөдөлмөрлөх эрхтэй)	Тусгай үйл ажиллагаа (Дээддээ нэг жил / Ажлын байр хадгалах / Хөдөлмөрлөх эрхтэй) Жич: Хугацаа сунгалтаар 4 сар сунгагдана
6	“Интерншип” хөтөлбөр (9-р тушаал) Үйлдвэрлэлийн салбарын гадаад ажилтан (42-р тушаал)	Тусгай үйл ажиллагаа (6 сар / Эх орон руу буцахад хүндрэлтэй / Хөдөлмөрлөх эрхтэй)	Тусгай үйл ажиллагаа (4 сар / Эх орон руу буцахад хүндрэлтэй / Хөдөлмөрлөх эрхтэй)
7	Гэрийн ажилд туслах гадаад ажилтан байсан	Тусгай үйл ажиллагаа (6 сар / Эх орон руу буцахад хүндрэлтэй / Хөдөлмөрлөх эрхгүй) (*)	Тусгай үйл ажиллагаа (4 сар / Эх орон руу буцахад хүндрэлтэй / Хөдөлмөрлөх эрхгүй) (*)

* Визийн статусаас гадуур үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан тохиолдолд долоо хоногт 28 цаг хүртэл хөдөлмөр эрхлэх эрх үүснэ.